ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Усны газрын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/24/НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | **Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**<br>Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn<br>**Аудитын менежер: Ч.Болд**<br>Утас: 261605 Цахим хаяг: Boldch@audit.gov.mn<br>**Ахлах аудитор: И.Эрдэнэцэцэг**<br>Утас: 261628 Цахим хаяг: Erdenetsetsegi@audit.gov.mn<br>**Аудитор: А.Баясгалан**<br>Утас: 261628 Цахим хаяг: Bayasgalana@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/839

танай ____________-ны № ____________-т

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ З.БАТБАЯР ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Усны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн нөлөөг эс тооцвол Усны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн харьяа байгууллагуудад илэрсэн санхүүгийн болон цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 587.1 сая төгрөгөөр өндөр бөгөөд дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байгаа нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 21 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 байгууллага "Хязгаарлалттай", 12 байгууллага "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч, 8 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны нийт төсөв 8,661.5 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд гүйцэтгэлээр 8,061.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 15 зорилтын хүрээнд 54 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг 90.5 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамааралгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* *∕мянган төгрөг∕*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,001,284.9** | **1,395,790.4** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **3,914.5** | **10,119.1** |
| **33** | **АВЛАГА** | **538,440.0** | **330,366.1** |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **2,104,104.0** | **548,800.0** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **354,826.4** | **506,505.2** |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,351,133.2** | **13,977,929.4** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7,351,133.2** | **13,977,929.4** |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **10,352,418.0** | **15,373,719.7** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **823.3** | **2,844.8** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **823.3** | **2,844.8** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **10,351,594.7** | **15,370,875.0** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **10,351,594.7** | **15,370,875.0** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 543,975.2 | 329,060.2 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 9,788,179.5 | 14,743,856.3 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 19,440.0 | 83,043.5 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **10,352,418.0** | **15,373,719.7** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */мянган төгрөг/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 12,179,645.3 | 17,822,878.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,392,386.0 | 7,118,189.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,392,386.0 | 7,118,189.9 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,787,259.3 | 10,704,688.5 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 9,780,356.0 | 12,720,034.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,649,168.3 | 11,030,145.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,928,701.8 | 9,858,131.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,895,752.3 | 4,575,187.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 365,389.3 | 573,666.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 233,105.3 | 241,834.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 393,832.7 | 551,052.4 |
| 2105 | Норматив зардал | 5,084.8 | 65,683.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 118,605.1 | 143,937.7 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 168,208.7 | 272,632.3 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,533,281.9 | 2,046,615.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,215,441.7 | 1,387,522.5 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 720,466.5 | 1,172,014.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 2,131,187.7 | 1,689,888.4 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,399,289.3 | 5,102,844.2 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 15,180.0 | - |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 62,048.1 | 130,289.5 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 2,352,421.2 | 4,972,554.7 |

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */мянган төгрөг/*

| Үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **7,972,934.8** | **-** | **7,972,934.8** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 26,238.7 | - | 26,238.7 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 7,999,173.5 | - | 7,999,173.5 |
| Тайлант үеийн үр дүн | 2,352,421.2 | - | 2,352,421.2 |
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,351,594.7** | **-** | **10,351,594.7** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (16,878.0) | - | (16,878.0) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 10,334,716.7 | - | 10,334,716.7 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 63,603.5 | - | 63,603.5 |
| Тайлант үеийн үр дүн | 4,972,554.7 | - | 4,972,554.7 |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **15,370,875.0** | **-** | **15,370,875.0** |

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* *\/мянган төгрөг/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **10,942,535.1** | **11,940,981.5** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **156,475.8** | **790,495.6** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **156,475.8** | **790,495.6** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **10,786,059.3** | **11,150,485.9** |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7,092,837.7** | **9,828,031.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,092,837.7** | **9,828,031.6** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,003,521.2** | **8,648,144.1** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,899,876.0** | **4,592,961.3** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **365,955.3** | **572,257.4** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **231,323.2** | **241,754.0** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **310,685.9** | **412,479.0** |
| **2105** | **Норматив зардал** | **7,979.7** | **62,762.5** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **266,885.1** | **334,397.2** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **168,026.2** | **268,607.6** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,699,276.2** | **2,078,169.1** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **53,513.7** | **84,755.9** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,089,316.5** | **1,179,887.5** |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,849,697.4** | **2,112,949.9** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **3,847,782.9** | **2,106,745.3** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,847,782.9** | **2,106,745.3** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,847,782.9** | **2,106,745.3** |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(3,847,782.9)** | **(2,106,745.3)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **1,914.5** | **6,204.6** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 2,000.0 | 3,914.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 3,914.5 | 10,119.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөг/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **8,661,483,900.00** | **8,061,145,423.94** | **600,338,476.06** | 93.1 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **8,661,483,900.00** | **8,061,145,423.94** | **600,338,476.06** | 93.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **8,372,414,600.00** | **7,863,671,393.94** | **508,743,206.06** | 93.9 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **4,922,418,300.00** | **4,545,065,158.07** | **377,353,141.93** | 92.3 |
| 210101 | Үндсэн цалин | 3,046,508,100.00 | 2,889,477,314.91 | **157,030,785.09** | 94.8 |
| 210102 | Нэмэгдэл | 1,073,439,600.00 | 942,639,776.01 | **130,799,823.99** | 87.8 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 399,376,000.00 | 376,741,624.86 | **22,634,375.14** | 94.3 |
| 210104 | Урамшуулал | 403,094,600.00 | 336,206,442.29 | **66,888,157.71** | 83.4 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **616,935,200.00** | **566,283,555.34** | **50,651,644.66** | 91.8 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 419,895,400.00 | 387,142,074.28 | **32,753,325.72** | 92.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 49,261,800.00 | 45,966,504.20 | **3,295,295.80** | 93.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 39,406,500.00 | 36,551,516.91 | **2,854,983.09** | 92.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,855,200.00 | 8,710,522.53 | **1,144,677.47** | 88.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 98,516,300.00 | 87,912,937.42 | **10,603,362.58** | 89.2 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **267,855,900.00** | **241,754,033.37** | **26,101,866.63** | 90.3 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 44,184,500.00 | 28,341,330.96 | **15,843,169.04** | 64.1 |
| 210302 | Түлш, халаалт | 62,952,100.00 | 59,571,385.17 | **3,380,714.83** | 94.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,035,500.00 | 8,188,917.24 | **7,846,582.76** | 51.1 |
| 210304 | Байрны түрээс | 144,683,800.00 | 145,652,400.00 | **(968,600.00)** | 100.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **246,964,300.00** | **238,352,971.35** | **8,611,328.65** | 96.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 30,500,900.00 | 30,350,355.00 | **150,545.00** | 99.5 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 150,691,300.00 | 143,961,159.00 | **6,730,141.00** | 95.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 35,934,900.00 | 34,627,147.35 | **1,307,752.65** | 96.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,896,800.00 | 1,615,430.00 | **281,370.00** | 85.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,940,400.00 | 27,798,880.00 | **141,520.00** | 99.5 |
| **2105** | **Норматив зардал** | **53,878,800.00** | **53,162,460.00** | **716,340.00** | 98.7 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 44,800,000.00 | 44,580,760.00 | **219,240.00** | 99.5 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 9,078,800.00 | 8,581,700.00 | **497,100.00** | 94.5 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **264,413,000.00** | **261,733,829.00** | **2,679,171.00** | 99.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 157,612,700.00 | 156,730,329.00 | **882,371.00** | 99.4 |
| 210602 | Тавилга | 426,600.00 | 426,600.00 | **-** | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 13,893,800.00 | 13,639,500.00 | **254,300.00** | 98.2 |
| 210604 | Урсгал засвар | 92,479,900.00 | 90,937,400.00 | **1,542,500.00** | 98.3 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **126,823,700.00** | **120,398,610.00** | **6,425,090.00** | 94.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 126,823,700.00 | 120,398,610.00 | **6,425,090.00** | 94.9 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,826,478,800.00** | **1,793,757,568.81** | **32,721,231.19** | 98.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,422,202,300.00 | 1,398,548,341.90 | **23,653,958.10** | 98.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,917,500.00 | 8,366,650.00 | **550,850.00** | 93.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 12,574,400.00 | 9,154,085.00 | **3,420,315.00** | 72.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 356,656,000.00 | 355,339,609.91 | **1,316,390.09** | 99.6 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,935,600.00 | 1,025,900.00 | **909,700.00** | 53.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 20,186,700.00 | 19,383,110.00 | **803,590.00** | 96.0 |
| 210807 | Газрын төлбөр | 1,477,300.00 | 121,872.00 | **1,355,428.00** | 8.2 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 350,500.00 | - | **350,500.00** | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,178,500.00 | 1,818,000.00 | **360,500.00** | 83.5 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,646,600.00** | **43,163,208.00** | **3,483,392.00** | 92.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,793,700.00 | 9,753,528.00 | **40,172.00** | 99.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 36,852,900.00 | 33,409,680.00 | **3,443,220.00** | 90.7 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **289,069,300.00** | **197,474,030.00** | **91,595,270.00** | 68.3 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **289,069,300.00** | **197,474,030.00** | **91,595,270.00** | 68.3 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,200,000.00 | 9,200,000.00 | **-** | 100.0 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 279,869,300.00 | 188,274,030.00 | **91,595,270.00** | 67.3 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **8,661,483,900.00** | **8,905,901,652.43** | **(244,417,752.43)** | 102.8 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **8,218,643,900.00** | **8,132,271,200.00** | **86,372,700.00** | 98.9 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 8,218,643,900.00 | 8,132,271,200.00 | **86,372,700.00** | 98.9 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **442,840,000.00** | **773,630,452.43** | **(330,790,452.43)** | 174.7 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 442,840,000.00 | 772,730,452.43 | **(329,890,452.43)** | 174.5 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 900,000.00 | **(900,000.00)** | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **532** | **532** | **-** | 100.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **22** | **22** | **-** | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 22 | 22 | **-** | 100.0 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **255** | **223** | **32** | 87.5 |
| 620001 | Удирдах ажилтан | 27 | 24 | **3** | 88.9 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 205 | 172 | **33** | 83.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 23 | 27 | **(4)** | 117.4 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **255** | **223** | **32** | 87.5 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 209 | 174 | **35** | 83.3 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 46 | 49 | **(3)** | 106.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан* */төгрөг/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **1,597,678,135.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **1,002,671,635.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **871,364,565.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | **47,896,131.55** |
| 210101 | Үндсэн цалин | | 17,328,328.43 |
| 210102 | Нэмэгдэл | | 30,567,803.12 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | **5,973,815.70** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 4,296,286.11 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 422,682.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 338,145.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 83,336.29 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 833,365.55 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **176,399,828.00** |
| 210401 | Бичиг хэрэг | | 13,389,246.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 130,905,460.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 247,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 31,857,422.00 |
| **2105** | **Норматив зардал** | | **9,600,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | | 9,600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **166,477,400.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 162,089,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | | 800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | | 3,587,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **148,033,138.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 148,033,138.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **284,411,552.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 208,313,552.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 76,098,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **32,572,700.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 20,792,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 11,780,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **131,307,069.88** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **112,172,750.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 112,172,750.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **19,134,319.88** |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 19,134,319.88 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **595,006,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | | **595,006,500.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 595,006,500.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **1,597,678,135.13** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **1,597,678,135.13** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 125,186,632.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 430,483,616.13 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 529,485,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 512,522,687.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 684.9 сая төгрөгийн зөрчил[1] илэрч 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 684.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 587.1 сая төгрөгөөр давсан тул "**Хязгаарлалттай**" дүгнэлт өглөө.

### 5.1 Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 21 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 13 байгууллагад дүгнэлт гаргаж, 8 байгууллагад аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн тайлангийн аудитаар 12 байгууллага "Өөрчлөлтгүй", 1 байгууллага "Хязгаарлалттай" санал дүгнэлт авсан байна.

Харьяа 21 байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар 719.6 сая төгрөгийн 14 алдааг залруулж, залруулаагүй 1 алдаанд зөвлөмж хүргүүлж, 13.9 сая төгрөгийн зөрчилд 14 төлбөр барагдуулах акт тогтоож, 29.2 сая төгрөгийн 7 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 65.0 сая төгрөгийн 12 зөрчилд зөвлөмж өгч, 548.0 сая төгрөгийн 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шалгуулахаар шилжүүллээ.

### 5.2 Албан шаардлага

1. Усны газрын 2023 оны санхүүгийн тайланд он дамнасан "Э" ХХК-аас авах 9.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "*төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй*", 6.4.8-д "*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Он дамжсан авлагыг барагдуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Тайлант онд албан хэрэгцээнд 18.6 сая төгрөгийн компьютер, принтерийг цахим дэлгүүрээс худалдан аваагүй , бусад  этгээдээс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "*Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно*", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.13-д "*Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс худалдан авах бараа, үйлчилгээг цахим дэлгүүрт байршуулснаас өөр этгээдээс худалдан авахыг хориглоно*" гэж заасантай тус тус  нийцээгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Ерөнхий гэрээний дагуу цахим дэлгүүрээс техник хэрэгсэл худалдан аваагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

3. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 21 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл хийсэн аудитаар санхүүгийн 657.0 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-д "*санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, ... бүртгэж, тайлагнах*", 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "*өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах*"; 16 дугаар зүйлийн 16.5.6-д "*дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*", 16.5.7-д "*байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах*" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрч буй алдаа, зөрчилд дүгнэлт хийж, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн асуудал

*Илрүүлэлт:* Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 21 байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар 142.2 сая төгрөгийн зөрчилд 3 зөрчил арилгах албан шаардлага, 34.2 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д "*өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах*"; 16 дугаар зүйлийн 16.5.6-д "*дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх*", 16.5.7-д "*байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах*" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрч буй нийцлийн алдаа, зөрчилд дүгнэлт хийж, дотоод хяналтыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Орхон-Чулуут голын сав газрын захиргаа | 1 | 1,581.2 | | | 1 | 1,581.2 | 1 | 1,581.2 | | | | |
| 2 | Сэлэнгийн голын сав газрын захиргаа | 3 | 4,971.2 | | | 3 | 4,971.2 | 3 | 4,971.2 | | | | |
| 3 | Ханwww голын сав газрын захиргаа | 2 | 2,400.0 | | | 2 | 2,400.0 | 2 | 2,400.0 | | | | |
| 4 | Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа | 1 | 372,400.4 | | | 1 | 372,400.4 | 1 | 372,400.4 | | | | |
| 5 | Хүйсийн говь-Цэцэг нуур сав газрын захиргаа | 5 | 334,501.5 | 1 | 15,064.0 | 4 | 319,437.5 | 5 | 334,501.5 | | | | |
| 6 | Хөвсгөл-Эгийн голын сав газрын захиргаа | 1 | 268.5 | | | 1 | 268.5 | 1 | 268.5 | | | | |
| 7 | Алтайн өвөр говийн сав газрын захиргаа | 1 | - | | | 1 | - | | - | 1 | - | 1 | - |
| 8 | Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа | 1 | 3,429.2 | | | 1 | 3,429.2 | 1 | 3,429.2 | | | | |
| **Нийт дүн** | | **15** | **719,552.0** | **1** | **15,064.0** | **14** | **704,488.0** | **14** | **719,552.0** | **1** | **-** | **1** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| 1 | Усны газар ТТЗ | 3 | 27,960.0 | | | 3 | 27,960.0 | | | | | | |
| 1 | Бөөнцагаан нуур-Орог нуур сав газрын захиргаа | 1 | 5,000.0 | | | 1 | 5,000.0 | | | | | | |
| 2 | Дэлгэр мөрөн шишхэд голын сав газрын захиргаа | 4 | 17,573.1 | 1 | 156.1 | | | 3 | 17,417.0 | | | | |
| 3 | За. Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаа | 2 | 1,492.3 | 2 | 1,492.3 | | | | | | | | |
| 4 | Орхон-Чулуут голын сав газрын захиргаа | 3 | 13,050.5 | 2 | 3,050.0 | | | 1 | 10,000.5 | | | | |
| 5 | Сэлэнгийн голын сав газрын захиргаа | 1 | 359.9 | 1 | 359.9 | | | | | | | | |
| 6 | Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газрын захиргаа | 2 | 1,907.1 | 2 | 1,907.1 | | | | | | | | |
| 7 | Хануй голын сав газрын захиргаа | 6 | 36,104.4 | 2 | 3,764.7 | 1 | 7,263.5 | 3 | 25,076.2 | | | | |
| 8 | Хар нуур-Ховд голын сав газрын захиргаа | 2 | 3,451.1 | | | | | 2 | 3,451.1 | | | | |
| 9 | Хэрлэн голын сав газрын захиргаа | 2 | 2,727.7 | 2 | 2,727.7 | | | | | | | | |
| 10 | Хүйсийн говь-Цэцэг нуур сав газрын захиргаа | 5 | 5,162.3 | 2 | 459.3 | 3 | 4,703.0 | | | | | | |
| 11 | Хөвсгөл-Эгийн голын сав газрын захиргаа | 1 | 2,703.9 | | | | | 1 | 2,703.9 | | | | |
| 12 | Алтайн өвөр говийн сав газрын захиргаа | 1 | 3,955.5 | | | | | 1 | 3,955.5 | | | | |
| 13 | Галба-Өөш-Долоодын говийн сав газрын захиргаа | 1 | 836.5 | | | 1 | 836.5 | | | | | | |
| 14 | Туул голын сав газрын захиргаа | 3 | 562,638.1 | | | 1 | 11,392.9 | 1 | 2,445.2 | | | 1 | 548,800.0 |
| **Нийт дүн** | | **34** | **684,922.5** | **14** | **13,917.3** | **10** | **57,155.9** | **12** | **65,049.4** | **-** | **-** | **1** | **548,800.0** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| № | Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Бөөнцагаан нуур-Орог нуур сав газрын захиргаа | 1 | 94,709.0 | | | 1 | 94,709.0 | | |
| 2 | Хануй голын сав газрын захиргаа | 1 | 29,474.6 | | | 1 | 29,474.6 | | |
| 3 | Хөвсгөл-Эгийн голын сав газрын захиргаа | 1 | - | | | | | 1 | - |
| 4 | Туул голын сав газрын захиргаа | 1 | 31,736.7 | | | | | 1 | 31,736.7 |
| | **Дүн** | **4** | **155,920.2** | **-** | **-** | **2** | **124,183.5** | **2** | **31,736.7** |
| | **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Усны газар ТТЗ | 3 | - | | | | | 3 | - |
| 2 | Хүйсийн говь-Цэцэг нуур сав газрын захиргаа | 2 | 18,000.0 | | | 1 | 18,000.0 | 1 | - |
| 3 | Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаа | 1 | - | | | | | 1 | - |
| 4 | Хараа-Ерөө голын сав газрын захиргаа | 1 | 2,488.2 | | | | | 1 | 2,488.2 |
| 5 | Туул голын сав газрын захиргаа | 1 | - | | | | | 1 | - |
| | **Дүн** | **8** | **20,488.2** | **-** | **-** | **1** | **18,000.0** | **4** | **2,488.2** |
| | **Нийт дүн** | **12** | **176,408.4** | **-** | **-** | **3** | **142,183.5** | **6** | **34,224.9** |